



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 46 (331)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Монгол Улсын 2004 оны төсвийн тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2003 он**



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2003 оны арванхоёрдугаар сарын 10 № 46 (331)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

586.	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2003-11-20-ны хууль)	986
587.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2003-11-20-ны хууль)	989
588.	Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2003-11-20-ны хууль)	990
589.	Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт оруулах тухай (2003-11-20-ны хууль)	990
590.	Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2003-11-20-ны хууль)	990
591.	Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2003-11-27-ны хууль)	991
592.	Хүн амын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай (2003-11-27-ны хууль)	991
593.	Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2003-11-27-ны хууль)	991
594.	Нэмэгдсэн ертгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2003-11-27-ны хууль)	992
595.	Монгол Улсын 2004 оны төсвийн тухай (2003-11-28-ны хууль)	992

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

596.	Үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 48	995
597.	Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай	Дугаар 49	1022
598.	Монгол Улсын 2004 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 51	1022



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, зүйл, бүлгийг тус тус нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 4 дэх заалт, мөн зүйлийн 7, 8 дахь хэсэг:

"4.6.4. татварын албаны санал, тодорхойлолт.

4.7. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар, согтууруулах ундаа импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар тус тус сунгана.

4.8. Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн¹ 6.3, 6.4-т заасан журмыг баримтална."

2/ 5 дугаар зүйлийн 11 дэх хэсэг:

"5.11. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь согтууруулах ундааны нэр, савлалтын хэмжээг татварын албанд мэдэгдэнэ."

3/ 6 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"6.3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, мөн зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэлгүйгээр худалдаа, үйлчилгээ явуулах байршлаа өөрчлөхийг хориглоно.

6.4. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг тухайн орон нутгийн хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршлыг харгалзан худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно."

4/ 7 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

"7.8. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газарт 00-06 цагт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно."

5/ 9 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"9.3. Согтууруулах ундааны зар сурталчилгааны материалыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

9.4. Ирган, аж ахуйн нэгж, байгууллага согтууруулах ундааны хор уршиг, хэрэглээний эсрэг сурталчилгааг ивээн тэтгэж болно."

6/ 5¹ дугаар зүйл:

"5¹ дугаар зүйл. Спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журам

5¹.1. Хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртийн хуваарилалт олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журмыг хүнсний, хууль зүйн, санхүү, эдийн засгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална."

7/ 13¹ дугаар зүйл:

"13¹ дугаар зүйл. Хураагдсан спирт, согтууруулах ундаанд шинжилгээ хийх, түүнийг борлуулах, устгах

13¹.1. Эрүүгийн хуулийн² 161, 175 дугаар зүйл, Захиргааны хариуцлагын тухай хуулийн³ 42 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, захиргааны зөрчлийн болон энэ хуулийг зөрчсөний улмаас цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, гааль болон мэргэжлийн хяналтын байгууллага, татварын албаны эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураагдсан буюу шүүхийн шийдвэрээр хураахаар эцэслэн шийдвэрлэгдсэн согтууруулах ундааг улсын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийж, дараахь дүгнэлтийн аль нэгийг гаргана:

13¹.1.1. эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, стандартын шаардлага хангасан тул хүнсэнд хэрэглэж болох;

13¹.1.2. техникийн болон хүнсний бус бусад зориулалтаар ашиглах;

13¹.1.3. энэ хуулийн 13¹.1.1, 13¹.1.2-т заасан зориулалтаар ашиглах шаардлага хангахгүй.

13¹.2. Согтууруулах ундааг хураах, шинжилгээ хийх, улсын орлого болгож борлуулах журмыг Засгийн газар батална.

13¹.3. Энэ хуулийн 13¹.1.3-д заасан согтууруулах ундааг устгах журмыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч болон

¹Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль-Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн

²Эрүүгийн хууль-Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн

³Захиргааны хариуцлагын тухай хууль-Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1992 оны 4, 5 дугаарт нийтлэгдсэн

Улсын ерөнхий прокурор хамтран батална.

8/ 13² дугаар зүйл:

13² дугаар зүйл. Архидан согтуурахтай тэмцэх сан

13².1. Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Архидан согтуурахтай тэмцэх сан /цаашид "сан" гэх/-г байгуулна.

13².2. Сангийн хөрөнгө нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

13².2.1. архидан согтуурахтай тэмцэх ажлыг дэмжиж иргэд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүнчлэн олон улсын болон гадаадын байгууллага, иргэд, харьяалалгүй хүнээс үзүүлсэн хандив, тусламжийн хөрөнгө.

13².2.2. Монгол Улсын хууль тогтоомжид үл харшлах бусад орлого.

13².3. Сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Монгол Улсын Засгийн газар батална.

13².4. Сангийн үйл ажиллагаанд шаардлагатай үед төрөөс дэмжлэг үзүүлж болно.

13².5. Архидан согтуурахтай тэмцэх ажлыг дэмжиж иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүнчлэн олон улсын болон гадаадын байгууллага, иргэд, харьяалалгүй хүмүүсээс үзүүлсэн хандив, тусламжийн хөрөнгө, бусад орлогыг сангийн дансанд бүртгэнэ.

13².6. Сангийн хөрөнгийг сангийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн дараахь зориулалтаар зарцуулна.

13².6.1. архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар гарсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл, сургалт, сурталчиггаа явуулах;

13².6.2. архины хэрэглээ, түүнээс үүдэн гарах хүн амын өвчлөл, нас баралт, хүчирхийлэл, осол гэмтлийн нийгмийн зардал, согтууруулах ундааны үйлдвэрлэлийн эдийн засгийн ашиг, зардлын үнэлгээг судлан тогтоож, архидан согтуурахаас сэргийлэх, түүнд хяналт тавих арга замыг тодорхойлох;

13².6.3. архины хор хөнөөл, хүний эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгэмд учрах хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх болон архины зохистой, соёлтой хэрэглээг олон нийтэд төлөвшүүлэх;

13².6.4. архинд донтох өвчтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээг боловсронгуй болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх;

13².6.5. архидан согтуурах явдалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй оролцсон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах."

2 дугаар зүйл. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.2-ын "байршлыг" гэсний дараа "болон хүчин чадлыг"; 4.5-ын 2 дугаар өгүүлбэрийн "Төсөл сонгон шалгаруулах" гэсний дараа "болон үйлдвэрлэлд хяналт тавих" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 4 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 2, 3, 6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 11, 16 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"4.1. Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн Засгийн газар олгож, хүчингүй болгоно.

Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хяналт тавих чиг үүргийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга олгож, сунгаж, хүчингүй болгоно."

2/ 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"4.4. Худалдаа үйлчилгээнд улсын техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангасан, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулсан, тохирлын гэрчилгээ авсан согтууруулах ундааг нийлүүнэ."

3/ 5 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

"5.2. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийг шугамын оролт, гаралтыг тоолууржуулсан зориулалтын төхөөрөмжөөр, технологийн горим, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд батлагдсан стандартын дагуу явуулна.

5.3. Согтууруулах ундааны шошго дээр барааны тэмдэг, оноосон нэр, улсын стандарт, найрлага, хатуулаг, нэр төрөл, үйлдвэрлэсэн газар, он, сар, өдрийг, шил, сав, хайрцаг дээр эрүүл



мэндийн анхааруулга, агуулагдах стандарт хэмжээг заасан байна."

4/ 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"5.6. Гадаад улсаас импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг тогтоосон техникийн зохицуулалтын баримт бичгийг худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

5/ 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"9.2. Дараахь хэлбэрээр согтууруулах ундаа сурталчлахыг хориглоно:

9.2.1. согтууруулах ундаа болон согтууруулах ундааны үйлдвэрийн нэр, тэмдэг, зураг ашиглах замаар согтууруулах ундааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, интернэт, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз болон бусад биет байдлаар гаргах;

9.2.2 энэ хуулийн 7.3.2-т заасан этгээдэд согтууруулах ундаа хэрэглэхийг зааж сургах;

9.2.3 согтууруулах ундаа үйлдвэрлэгч нь өөрийн аж ахуйн нэгжийн нэртэй ижил нэрээр нэрлэсэн согтууруулах ундаа үйлдвэрлэх;

9.2.4 согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, экспорт эрхэлдэг, согтууруулах ундаа борлуулдаг хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүнийг сурталчлах, нэрийг нь олонд таниулах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор соёл, урлаг, спортын болон бусад олон нийтийн арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг үзүүлэх;

9.2.5 эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэх;

9.2.6 согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээний талаар төрөл бүрийн сугалаа, хонжвор, аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа явуулах."

6/11 дүгээр зүйл:

"11 дүгээр зүйл. Албадан эрүүлжүүлэх

11.1. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх ажиллагааг хуулиар зохицуулна."

7/ 16 дугаар зүйл:

"16 дугаар зүйл. Хариуцлага

16.1. Энэ хуулийг зөрчсөн этгээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

16.1.1. энэ хуулийн 4.4, 4.5-д заасныг зөрчсөн бол аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгож, уул согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хурааж, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

16.1.2. энэ хуулийн 5.1, 5.2, 5.5, 5.1-д заасныг зөрчсөн бол согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, уул согтууруулах ундаа, хууль бусаар олсон орлого болон согтууруулах ундаа үйлдвэрлэхэд ашигласан тоног төхөөрөмж, байрыг хураах;

Тайлбар: энэ хуулийг зөрчиж согтууруулах ундаа үйлдвэрлэх байгааг мэдэж байсан өмчлөгчийн тоног төхөөрөмж, байрыг хураана. Энэ тайлбар нь энэ хуулийн 16.1.4-т нэгэн адил хамаарна.

16.1.3. энэ хуулийн 5.3, 7.6-д заасныг зөрчсөн бол иргэнийг 35000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгож, уул согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хурааж, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

16.1.4. энэ хуулийн 5.4-д заасныг зөрчиж, согтууруулах ундаа үйлдвэрлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол зөвшөөрлийг хүчингүй болгож, 250000 төгрөгөөр торгож, уул зөвшөөрлийг хууль бусаар ашигласан аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн согтууруулах ундаа, хууль бусаар олсон орлого болон согтууруулах ундаа үйлдвэрлэхэд ашигласан тоног төхөөрөмж, байрыг хурааж, зөвшөөрөлд таагдсан үйлдвэрийн байршлыг дур мэдэн өөрчилсөн бол 250000 төгрөгөөр торгож, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

16.1.5. энэ хуулийн 5.8, 7.7, 7.8-д заасныг зөрчсөн бол иргэнийг 35000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгож, уул согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хурааж, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, уг аж ахуйн нэгж, байгууллагад дахин тусгай зөвшөөрөл олгох хугацааг 2 жилээр түдгэлзүүлэх;

16.1.6. энэ хуулийн 5.9, 5.10-д заасныг зөрчсөн бол уул согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хурааж хууль бус үйлдэлдээ ашигласан тээврийн хэрэгслийг хураах;

16.1.7. энэ хуулийн 6.1-д заасныг зөрчсөн бол иргэнийг 35000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгож, уул согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хураах;

16.1.8. энэ хуулийн 6.3-т заасныг зөрчиж, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол 200000 төгрөгөөр торгож, уг зөвшөөрлийг хүчингүй болгож, зөвшөөрлийг хууль бусаар ашигласан аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хурааж, 150000-200000 төгрөгөөр торгох;

16.1.9. энэ хуулийн 7.1, 7.2.1, 7.4, 7.5-д заасныг зөрчсөн бол иргэнийг 10000-15000, албан тушаалтныг 45000-60000 төгрөгөөр торгох;

16.1.10. энэ хуулийн 7.2.2-т заасныг зөрчсөн бол аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-200000 төгрөгөөр торгож, энэ зөрчлийг нэг жилийн дотор давтан гаргасан бол 200000-250000 төгрөгөөр торгож, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

16.1.11. энэ хуулийн 8.1-д заасныг зөрчсөн бол иргэнийг 30000-50000, албан тушаалтныг 35000-60000 төгрөгөөр торгох;

16.1.12. энэ хуулийн 9.2, 9.3-т заасныг зөрчсөн бол албан тушаалтныг 35000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгож, согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

16.1.13. энэ хуулийн 14.4-т заасныг зөрчсөн бол албан тушаалтныг 35000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгож, согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.

16.2. Энэ хуулийн 4.4, 5.1, 5.2, 5.4, 5.5, 5.9, 5.10, 5.1, 6.1, 6.2, 6.3-д заасныг зөрчсөн бол согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг дахин олгохгүй.

16.3. Энэ хуулийн 16.1-д заасан захиргааны зөрчлийг эрх бүхий албан тушаалтан дараахь харьяалаар хянан шийдвэрлэнэ:

16.3.1. шүүгч энэ хуулийн 5.1, 5.4, 5.5, 5.9, 5.10, 5.1, 6.1, 7.7, 8.1, 9.2, 9.3-т заасан зөрчил;

16.3.2. бүх шатны Засаг дарга энэ хуулийн 5.8, 5.9, 5.10, 5.1, 6.1, 6.3, 7.7, 8.1, 9 дүгээр зүйлд заасан зөрчил;

16.3.3. цагдаагийн эрх бүхий ажилтан энэ хуулийн 5.3, 5.4, 5.1, 6.1, 7, 8 дугаар зүйл, 9.2, 9.3-т заасан зөрчил;

16.3.4 хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч энэ хуулийн 4.4, 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.8, 5.9, 5.10, 5.1, 6.3, 7.1, 7.6, 9.2, 9.3-т заасан зөрчил;

16.3.5. нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч энэ хуулийн 6.1, 7.1, 7.2, 7.3.2, 7.4, 9.2.2-т заасан 20000 хүртэлх төгрөгийн торгууль ногдуулах зөрчил.

16.4. Үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг захиргааны зөрчлийг ногдуулах эрх бүхий албан тушаалтны шалгалтын дүн: саналыг үндэслэн уг зөвшөөрлийг олгосон байгууллага шийдвэрлэнэ.

16.5. Спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журам зөрчиж олгосон спиртээр үйлдвэрлэсэн согтууруулах ундаанд ногдох онцгой албан татварыг буруутай аж ахуйн нэгж, байгууллага төлнө.

16.6. Энэ хуулийн 5.1, 6.1-д заасныг зөрчиж үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүй явуулсан бол тухайн аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авна.

16.7. Энэ хуулийг зөрчсөн зөрчил бүрийг тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг ноцтой зөрчсөн гэж үзнэ."

4 дүгээр зүйл. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7.2.2, 7.4-ийн "18", 7.3.2-ын "арван найман" гэснийг "21" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10-д "15.10.12. согтууруулах ундаа импортлох." гэсэн заалт нэмсүгэй.

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.4-ийн "удаа дараа" гэсний дараа "букуу ноцтой" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3/ хууль бусаар олсон орлого, ад зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 15 дугаар зүйлд дор дурдсан хэсэг нэмсүгэй:

15.5. Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээг Засгийн газар тогтооно."

"15.4. Энэ хуулийн 15.1 нь согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээнд хамаарахгүй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ ӨВЧТЭЙ ЭТГЭЭДИЙГ ЗАХИРГААНЫ ЖУРМААР АЛБАДАН ЭМЧЛЭХ, АЛБАДАН ХӨДӨЛМӨР ХИЙЛГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "цагдаагийн" гэсний дараа "болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх" гэж нэмсүгэй.

хяналтад авахтай холбогдсон хэрилцаар зохицуулахад оршино."

2/ 8 дугаар зүйл:

"8 дугаар зүйл. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын харьяалал

2 дугаар зүйл. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, хөдөлмөр хийлгэх тухай хуулийн 1, 8 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг, 12 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

8.1. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяалалд байх бөгөөд түүний албадан эмчлэх мэргэжлийн удирдлагыг эрүүл мэндийн байгууллага, албадан хөдөлмөрлүүлэх мэргэжлийн удирдлага болон харуул хамгаалалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тус тус хэрэгжүүлнэ."

1/ 1 дүгээр зүйл:

3/11 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь төрөөс согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг уг өвчнөөс нь ангижруулах зорилгоор албадан эмчлэх, хөдөлмөрийн чадварыг нь харгалзан албадан хөдөлмөр хийлгэхээр эрүүл мэндийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын

"11.3. Согтуурах, мансуурах донтой этгээд эмчлүүлэхээс зайлсхийх боломжгүй, байнгын харуул хамгаалалт бүхий эмнэлэгт албадан эмчилгээг явуулна.

11.4. Албадан эмчлэх газрын нөхцөл, дэглэмийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, албадан эмчлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус Улсын ерөнхий прокурортой хамтран батална."

4/12 дугаар зүйл.

"12 дугаар зүйл. Албадан эмчлэх хугацаа

12.1. Албадан эмчилгээг өвчний онцлог, эмчилгээний үр дүнгээс шалтгаалан гурваас зургаан сар хүртэл, давтан эмчлүүлэх тохиолдолд зургаан сараас нэг жил хүртэл хугацаатай хийнэ.

12.2. Албадан эмчилгээний хугацаа нь тухайн этгээдийн эмчилгээний үр дүнг харгалзан мэргэжлийн эмч нарын комиссын дүгнэлтийг үндэслэн шүүхийн шийдвэрээр дуусгавар болно."

3 дугаар зүйл. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлд дараахь хэсэг нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 18 дахь хэсэг:

"18. Энэ зүйлийн 5, 6, 11 дэх хэсэгт завсан хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдэлж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж ийнхүү татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх хуульд заасан хугацаа дуусахаас өмнө татан буугдсан тохиолдолд тухайн аж ахуйн нэгжид олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг тэр хэмжээгээр нөхөн төлүүлнэ."

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "40" гэснийг "30" гэж; "1998" гэснийг "2004" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн "40" гэснийг "30" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн 3.1-ийн "Тэмдгийг" гэсний дараа "үнэгт цаас үйлдвэрлэгч гадаадын болон" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"4.4. Энэ хуулийн 4.3 дахь хэсэгт заасан иргэн, хуулийн этгээдийн нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын хэмжээ нь мөн хуулийн 3.1.9-д заасан хэмжээний 80 хувьд хүрсэн нь сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан болон иргэний орлого, татвар тодорхойлох хуудсаар нотлогдсон, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг шаардлагын хэмжээнд хөтөлж хэвшсэн тохиолдолд тухайн иргэн, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн

албан татвар төлөгчөөр бүртгүүлэхийг өөрөө хүсвэл татвар төлөгчөөр бүртгэж болно."

2/ 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалт:

"11.4.3. үйлдвэрлэгч-экспортлогчоос бусад татвар төлөгчийн татварыг төсвөөс улиралд нэг удаа буцаан олгох."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН 2004 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

Монгол Улсын 2004 оны төсвийн орлого, зарлага

1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын төсөвт 2004 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарлагын хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс татан төвлөрүүлэх орлогын хэмжээг тогтоох, төсвийн ерөнхийлөн захирагчдад төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Монгол Улсын 2004 оны төсвийн тухай хууль тогтоомж

Монгол Улсын 2004 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Нэгдсэн төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2004 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн орлогын доод хэмжээг 553,332,691.3 мянган төгрөгөөр баталсугай.

4 дүгээр зүйл. Монгол Улсын төсвөөс 2004 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын дээд хэмжээг 639,327,663.7 мянган төгрөгөөр баталсугай.

5 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2004 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид, түүний харъяа байгууллагууд, бусад байгууллагуудын төвлөрүүлэх орлогын дүнг дараахь байдлаар баталсугай.

	/мянган төгрөгөөр/
5.1. Монгол Улсын Ерөнхий сайд	18,734,477.7
5.1.1. Төрийн өмчийн хороо	13,755,000.0
5.1.2. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	4,979,477.7
5.2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	732,017.1
5.2.1. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	732,017.1
5.3. Гадаад хэргийн сайд	4,407,679.5
5.3.1. улсын тэмдэгтийн хураамж	3,731,422.6
5.3.2. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	676,256.9
5.4. Санхүү, эдийн засгийн сайд	401,782,135.4
5.4.1. Үндэсний татварын ерөнхий газар	173,400,317.9
5.4.2. Улсын гаалийн ерөнхий газар	210,111,600.0
5.4.3. Төрийн сан	18,270,217.5
5.5. Хууль зүй, дотоод хэргийн сайд	6,269,280.6
5.5.1. Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар	4,811,000.0
5.5.2. Иргэний бүртгэл, мэдээллийн төв	55,650.0
5.5.3. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	1,402,630.6
5.6. Байгаль орчны сайд	2,161,482.4
5.6.1. Байгаль орчныг хамгаалах алба	2,044,332.4
5.6.2. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	117,150.0
5.7. Батлан хамгаалахын сайд	591,193.5
5.7.1. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	591,193.5
5.8. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	22,718,278.8
5.8.1. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	22,718,278.8
5.9. Дэд бүтцийн сайд	22,840,322.6
5.9.1. Иргэний нисэхийн ерөнхий газар	13,435,000.0
5.9.2. Төмөр замын Хэрэг эрхлэх газар	812,500.0
5.9.3. Цахилгаан, шуудан холбооны газар	8,460,000.0
5.9.4. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	132,822.6
5.10. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	103,558,288.4
5.10.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар	101,803,107.9
5.10.2. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	1,755,180.5
5.11. Үйлдвэр, худалдааны сайд	4,729,902.5
5.11.1. Газрын тосны хэрэг эрхлэх газар	800,160.0
5.11.2. Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар	3,827,562.5
5.11.3. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	102,180.0
5.12. Хүнс, хөдөө аж ахуйн сайд	99,357.4
5.12.1. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	99,357.4
5.13. Эрүүл мэндийн сайд	2,921,331.0
5.13.1. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	2,921,331.0
5.14. Үндэсний статистикийн газар	3,500.0
5.14.1. харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлого	3,500.0
5.15. Монголбанк	8,900,000.0

6 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2004 дор дурдсанаар төсөв зарцуулах эрхийг олгосугай. Оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдад

	/мянган төгрөгөөр/
6.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	807,194.3
6.2. Монгол Улсын Их Хурлын дарга	2,883,674.9
6.3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцгийн дарга	88,938.6
6.4. Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч	216,968.1
6.5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга	2,484,311.2
6.6. Улсын ерөнхий прокурор	1,874,311.2
6.7. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	60,931.3
6.8. Монгол Улсын Ерөнхий сайд	16,292,079.2
6.9. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	4,009,363.9
6.10. Гадаад хэргийн сайд	8,148,940.5
6.11. Санхүү, эдийн засгийн сайд	115,975,873.0
6.12. Хууль зүй, дотоод хэргийн сайд	48,019,959.9
6.13. Байгаль орчны сайд	5,212,576.9
6.14. Батлан хамгаалахын сайд	20,742,292.2
6.15. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	138,382,703.5
6.16. Дэд бүтцийн сайд	60,705,409.0
6.17. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	149,510,884.5

6.18.Үйлдвэр, худалдааны сайд	3,396,820.5
6.19.Хүнс, хөдөө аж ахуйн сайд	18,872,214.0
6.20.Эрүүл мэндийн сайд	78,631,231.9
6.21.Төрийн албаны зөвлөлийн дарга	134,065.2
6.22.Сонгуулийн ерөнхий хорооны дарга	1,048,599.0
6.23.Хүний эрхийн үндэсний комиссын дарга	73,961.5
6.24.Монгол Улсын ерөнхий аудитор	166,689.2
6.25.Үнэт цаасны хорооны дарга	93,855.3
6.26.Үндэсний статистикийн газрын дарга	615,901.6
6.27.Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга	1,054,844.8

7 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2004 оны төсвийн жилд дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх нийт хөрөнгө оруулалтын хэмжээг 46,224,500.0 мянган төгрөгөөр, үүнээс шинээр эхлэх хөрөнгө оруулалтын хэмжээг 22,931,000.0 мянган төгрөгөөр, үүнээс 2004 онд санхүүжүүлэх объектийн төсөвт өртгийг 5,346,900.0 мянган төгрөгөөр, гадаад эх үүсвэрээр гүйцэтгэх авто замын байгууламжийн хөрөнгө оруулалтын хэмжээг 21,099,289.1 мянган төгрөгөөр баталсугай.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс татан төвлөрүүлэх орлого

8 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2004 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг дор дурдсанаар баталсугай.

	/мянган төгрөгөөр/
Нийт дүн	8,138,681.7
8.1.Архангай	340,120.6
8.2.Баян - Өлгий	339,648.1
8.3.Баянхонгор	619,320.1
8.4.Булган	367,508.7
8.5.Говь – Алтай	747,592.2
8.6.Дорнод	164,242.8
8.7.Дундговь	440,440.5
8.8.Завхан	651,060.5
8.9.Өвөрхангай	498,059.0
8.10.Өмнөговь	462,951.7
8.11.Сүхбаатар	382,432.1
8.12.Сэлэнгэ	423,322.9
8.13.Төв	683,686.3
8.14.Увс	622,322.3
8.15.Хөвсгөл	558,629.9
8.16.Ховд	295,287.0
8.17.Хэнтий	389,280.8
8.18.Говьсүмбэр	152,776.2

9 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн төсвөөс орон нутгийн төсөвт татан төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

Нийт дүн	17,470,779.8
9.1.Дорноговь	107,436.3
9.2.Дархан Уул	345,418.9
9.3.Улаанбаатар	10,005,729.4
9.4.Орхон	7,012,195.2

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

10 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны

1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газар, яам, агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны бүх шатны байгууллагад үүрэг болгосугай.

1. "Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр"-ийг нэгдүгээр, "Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд, эрхлэх асуудлын хүрээ, орон нутгийн хэмжээнд зохион байгуулж ажиллахыг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Улсын Их Хурлын 2003 оны 48 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

АРХИДАН СОГТУУРАХААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэсний хөтөлбөрийн үндэслэл, шаардлага

сонголт буруу байгааг ДЭМБ онцлон тэмдэглэсэн байна.

1.1. Согтууруулах ундааны хэрэглээ, архидалтын улмаас хүн амын эрүүл мэнд, нийгмийн амьдралд учирч байгаа хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх талаархи дэлхий дахины бодлого, чиг хандлага

Архи хэтрүүлэн хэрэглэх эрсдэлт зан үйл, архи, сэтгэцийн нөлөөт бодисын хамааралтай өвчнийг тоо дэлхийн олон оронд өсөн нэмэгдэж, улмаар улс үндэстний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байгааг харгалзан ДЭМБ-аас хүн амын согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэн гарах сөрөг үр дагаврыг бууруулах талаар хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг гишүүн орнууддаа зөвлөмж болгосон юм.

Сүүлийн хэдэн арван жил согтууруулах ундааны хэрэглээ хөгжингүй орнуудад буурч, харин хөгжиж буй орнуудад нэмэгдэн дэлхийн хэмжээнд жил бүр 1.8 сая хүн согтууруулах ундаа хэрэглэсэнтэй холбоотойгоор нас барж байгаа нь өвчин, эмгэгийн улмаас нас барсан нийт тохиолдлын 3,2 хувийг эзэлж байна.

ДЭМБ-аас хүн амын согтууруулах ундааны хэрэглээг багасгах хамгийн үр нөлөө бүхий арга зам нь татвар, үнийн бодлогоор дамжуулан согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд зохицуулалт хийн хангамжийг ерөнхийд нь бууруулах, үйлдвэрлэх, импортлох, худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлыг чангатган худалдах, үйлчлэх цэгийн тоог цөөрүүлэх, согтууруулах ундааны аливаа хэлбэрийн зар сурталчилгаа, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох, архи хэрэглэж болох насны доод хязгаарыг тогтоох явдал гэж үзэж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/ архидан согтуурууны улмаас хордох, архинд донтох өвчтэй болохоос гадна зүрхний титэм судасны өвчин, тархинд цус харвах, чихрийн шижин зэрэг 60 гаруй өвчин архидалттай ямар нэг хэмжээгээр холбоотой үүсч даамжирч байгаагийн дотор элэгний хатуурал, улаан хоолой, элэгний хавдар, эпилепси болон осол гэмтэл, санаатайгаар хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулж байгаа тохиолдлын 20-30 хувь нь архидалтаас үүдэлтэй байна гэж тооцоолжээ.

1.2. Монгол улс дахь согтууруулах ундааны хэрэглээ, архидалтын улмаас хүн амын эрүүл мэнд, нийгмийн амьдралд учирч байгаа хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Дэлхийн олон оронд нийгэм, эдийн засгийн шилжилт явагдаж байгаа энэ үед хүн амын аж төрөх хэвшил, эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйл өөрчлөгдөж, архийг хэрэглэх хэрэглээ, энэ чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний

1.2.1. Эрх зүйн орчин



Төр, засгаас архидаг согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг анхааралдаа авч Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гаалийн болон Гаалийн тарифын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Онцгой албан татварын тухай хууль, Хүнсний тухай хууль, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай болон бусад хуулиудаар тус тус зохицуулж байгаагийн дээр эдгээр хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан Засгийн газрын тогтоол, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын тушаал, шийдвэр гээд бүхэл бүтэн хууль, эрх зүйн орчин бүрджээ.

Гэвч эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт шалгалтын чанар, үр нөлөө хангалтгүй, хил, гааль, мэргэжлийн хяналт, хуулийн байгууллагын ажлын уялдаа холбоо муу байгаагаас архидалт, түүнээс үүдэн гарах хор хохирлын хэмжээ буурахгүй, харин ч нэмэгдсээр байна.

1.2.2. Үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ

Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, түүгээр үйлчлэх үйл ажиллагаанд төвх хяналт, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

1.2.2.1. үйлдвэрлэл: Одоо улсын хэмжээнд 12 спиртийн үйлдвэр, 173 архины үйлдвэр, 29 пивоны үйлдвэр ажиллаж байна. 2001 онд согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг 660 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний 79,1 хувь нь улсын стандартад заасан чанар, аюулгүйн шаардлагыг хангахгүй, 3,3 хувь нь зөвшөөрөлгүй, 18,3 хувь нь хууль бус үйл ажиллагаа явуулж байв. 2002 онд 4,9 сая литр спирт, 9,4 сая литр архи, дарс, 3,3 сая литр пиво үйлдвэрлэсэн нь өмнөх оныхтой харьцуулахад спиртийн үйлдвэрлэл 23,7, архи, дарсных 9,4 хувиар нэмэгдэж, харин пивоны үйлдвэрлэл 20,9 хувиар буурсан байна.

1.2.2.2. импорт: 2002 оны байдлаар 15,0 сая литр согтууруулах ундаа /үүнээс 13,5 нь пиво/ импортолсон нь өмнөх оныхтой харьцуулахад 4,8 хувиар өсчээ. 1999-2001 он, 2002 оны эхний улирлын байдлаар улсын хэмжээнд 740 аж ахуйн нэгж улсын хил, гаалиар 26,6 сая ам. долларын үнэ бүхий 44,8 сая литр согтууруулах ундаа оруулж ирснээс дөнгөж 17,3 сая литр нь буюу 38,7 хувь нь Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн баталгаажуулалтад хамрагдсан байна.

1.2.2.3. худалдаа, үйлчилгээ: Согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг цэгийн тоо хэт олширноос хүн ам, ялангуяа хүүхэд,

залуучууд оршин суугаа газар болон сургууль, ажлын газраасаа 50-700 метр яваад л хүссэн цагтаа /24 цаг/ согтууруулах ундаа авч хэрэглэх боломжтой байгаа нь хүн амын согтууруулах ундааны хэрэглээ ихсэхэд нөлөөлж байна. Одоо улсын хэмжээнд 48 хүнсний бөөний төв, 3482 хүнсний дэлгүүрт согтууруулах ундаа худалдаж байгаа бөгөөд тохирлын гэрчилгээ, чанарын баталгаагүй согтууруулах ундаа худалдах зөрчил нийтлэг байна. Сүүлийн жилүүдэд согтууруулах ундаагаар үйлчилдэг рестораны, баарны тоо нэмэгдэн одоо улсын хэмжээнд 338 ресторан, зоогийн газар, 1297 баар, цэнгээний газар согтууруулах ундаагаар үйлчилж байна. 2002 оны эцсийн байдлаар эвхэн нийслэлийн хэмжээнд 199 зоогийн газар, 557 баар, 1438 хүнсний дэлгүүр согтууруулах ундаа худалдаж, түүгээр үйлчилж байгаа нь өмнөх оныхтой харьцуулахад 16,4-17,5 хувиар тус тус нэмэгдсэн төдийгүй баар, цэнгээний газрууд үйлчилгээний цагийн хуваарийг 1-3 цагаар хэтрүүлэх зөрчил гарсаар байна.

1.2.2.4. хууль бус худалдаа: Улсын хил, гаалиар нууцаар оруулж ирсэн болон хуваариас гадуур спиртээр үйлдвэрлэсэн татвар ногдоогүй архи нь онцгой албан татвар тооцох жишиг үнээс доогуур хямд үнээр хөдөө орон нутаг, нийслэлийн захын дүүргүүдэд борлуулагдаж байгаа нь согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байна. Тухайлбал, 2002 онд онцгой албан татвар ногдуулах жишиг үнээс доогуур хямд борлуулж байсан 24,1 мянган шил архи, түүнчлэн гаалийн тухай хууль тогтоомж зөрчсөн, эрүүгийн хэрэг үйлдсэн болон захиргааны зөрчил гэгэсэн 2936 аж ахуйн нэгж, иргэдээс 106,0 мянган литр спирт, 23,4 мянган литр архи, 696 литр дарсыг хураан авч зохих журмын дагуу шийдвэрлэсэн байна.

1.2.3. Архидалт ба эдийн засаг

Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт нэмэгдэж, 2002 онд дотоодын үйлдвэрлэлд ногдуулсан онцгой албан татвараас 21,2 тэрбум төгрөгийн орлого, 2002 онд импортолсон согтууруулах ундаанд ногдуулсан бүх төрлийн татвараас 6,6 тэрбум төгрөг улсын төсөвт тус тус төвлөрсөн байна.

Гэтэл архидаг согтуурсны улмаас улс орны нийгэм, эдийн засгийн байдалд шууд болон шууд бусаар учирч байгаа хохирлын хэмжээ улам бүр нэмэгдсээр байна.

1.2.4. Согтууруулах ундааны хэрэглээний байдал

Тус улсын нийт хүн амын дунд явуулсан архинд донтох өвчний тархалтын судалгаагаар /

1985-1997/ насанд хүрэгчдийн 51,2 хувь нь архийг хэтрүүлэн хэрэглэж байгаагийн 8 хувь нь эмгэгтэйчүүд байна. 2000 онд НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ, НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллагууд ЭМЯ-тай хамтран явуулсан судалгаагаар өсвөр үеийнхний архи хэрэглэж эхэлсэн дундаж нас 17,6 байгаа бөгөөд 20-иос доош насны өсвөр үеийнхний 70,5 хувь нь архи хэрэглэж үзсэн, хотын хүүхдүүд хөдөөгийнхийг бодвол хоёр дахин их хэмжээний согтууруулах ундаа хэрэглэж байгааг тогтоожээ.

Манай улсын насанд хүрсэн /15 наснаас дээш/ нэг хүнд ногдож байгаа бүх төрлийн согтууруулах ундааг 38 градусын архинд шилжүүлснээр тооцоход 1998 онд 4,7 литр архи ногдож байсан бол 2000 онд 7,81, 2001 онд 7,47, 2002 онд 9,03 литр болж өссөн байна. Үүнээс гадна албан ёсны бүртгэлгүй буюу хууль бусаар улсын хил, гаалиар оруулсан, хуваариас гадуурх спиртээр үйлдвэрлэсэн, мөн иргэдийн худалдааны бус зориулалтаар улсын хилээр нэг удаа оруулсан, гэрийн нөхцөлд хийж байгаа согтууруулах ундааг нэмж тооцвол энэ үзүүлэлт дээрх тооноос их байгаа нь тодорхой юм.

1.2.5. Архидалтын сөрөг үр дагавар

1.2.5.1. архидалт ба гэмт хэрэг:

Архидан согтуурах явдал гэмт хэрэг гарах үндсэн нөхцөл болсоор байна. 2002 оны байдлаар улсын хэмжээнд гарсан нийт гэмт хэргийн дотор согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 18,6 хувийг эзэлж байгаа нь өмнөх оныхоос 13,3 хувиар, согтуугаар гэмт хэрэг үйлдэгчдийн тоо нийт гэмт хэрэг үйлдэгчдийн дотор 21,2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оныхоос 14,5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна /гэхдээ сүүлийн арваад жил гэмт хэрэг, согтуугаар үйлдсэн гэмт хэргийн тоо манай улсад маш ихээр өссөн учир дээрх тоо тийм ч бага тоо биш юм/.

1.2.5.2. архидалт ба эрүүл мэнд:

Архидан согтуурснаас учирсан эрүүл мэндийн хохирол жилээс жилд нэмэгдэж, халдварт бус өвчин, осол гэмтэл, хүн амын өвчлөл, нас баралтын зонхилох шалтгаан болж байна. Тухайлбал, сүүлийн 10 жилд зурх судасны эмгэгээр нас барах явдал 4-5 дахин нэмэгдэж, хүн амын нас баралтын шалтгааны дотор 1 дүгээрт, хавдар 2 дугаарт орох болж, нас барж байгаа 6 хүн тутмын нэг нь энэ /хавдар/ өвчний улмаас эндэх боллоо.

Хорт хавдрын бүтцэд элэг, ходоод, улаан хоолойн хавдар зонхилж, нийт хавдрын 60 гаруй хувийг эзэлж байна. 2001 онд улсын хэмжээнд элэгний хатуурлын улмаас тохиолдсон нас баралт хоол боловсруулах замын өвчнөөс шалтгаалсан нийт нас баралтын 27,5 хувийг эзэлж байна.

Осол, гэмтэл, хордлого 1980 онтой харьцуулахад 4 дахин нэмэгдэж, хүн амын нас баралтын шалтгааны дотор 3 дугаарт орох болов. Зөвхөн 2002 оны байдлаар осол, гэмтлийн улмаас гарсан нийт нас баралтын 52,5 хувь нь согтуугаар осолд өртөн нас барсан тохиолдол байна.

1999 онд АУИС-ийн /хуучин нэрээр/ Мэдрэл, сэтгэц судлалын тэнхимээс хийсэн судалгаагаар оюуны хомсдолтой хүүхдүүдийн эцэг, эхийн 58,4 хувь нь архи хэтрүүлэн хэрэглэж байсан нь архи хүний үр удамд хэрхэн нөлөөлдгийг харуулж байна.

Архинд гүн хордож нас барсан хүний тоо жилээс жилд нэмэгдэж, зөвхөн сүүлийн 5 жилд 1005 хүн амь насав алджээ. Сүүлийн 10 жилд архинд донтох өвчтэй хүний тоо 2 дахин нэмэгдэж 2000 оны байдлаар уг өвчний тархалт 1000 хүнд хотод 6,4, хөдөөд 2,5 байна.

Хүн амын дундаж наслалтыг хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 3-7 жилээр дутуу насалж байгаа нь согтууруулах ундааны хэрэглээ эрэгтэйчүүдийн дунд илүү байгаатай холбоотой юм.

1.2.5.3. архидалт ба гэр бүл:

Архидан согтуурах нь гэр бүл дэх хүчирхийлэл, гэр бүл салалт, ажил таслалт, сургууль завсардалт болон хүүхэд өсвөр үеийнхний архи ууж, тамхи татах, мансуурах хорт зуршилд автах шалтгааны нэг болж байна.

2000 онд НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ, НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллагууд ЭМЯ-тай хамтран явуулсан судалгаагаар гэр бүлийн гишүүдийн аль нэг нь архи уудаг айлын 10 хүүхэд тутмын нэг нь сурлага муутай, 4 хүүхдийн нэгэнд нь зан үйлийн сөрөг өөрчлөлт гарч байгаа төдийгүй 10 орчим хувь нь архи ууж, 5 хувь нь гэрээсээ дайжиж байгааг тогтоожээ. Хүчирхийллийн эсрэг төвийн мэдээгээр гэр бүлийн хүчирхийллийн 60 орчим хувь, гэр бүл салалтын 45 хувь нь архидалттай холбоотой байна.

1.2.6. Архины хор хөнөөлийн талаар хүн амын мэдлэг, хандлага, дадал

Архины хор хөнөөлийн талаар хүн ам, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхний мэдлэг хангалтгүй байгааг 1997 онд Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийн /хуучин нэрээр/ явуулсан судалгаагаар түүнд хамрагдсан хүүхэд, өсвөр үеийнхний 19,3 хувь нь сайн, 49,4 хувь нь дунд, 12,2 хувь нь хангалтгүй, 19,1 хувь нь огт мэдэхгүй гэж хариулсан судалгааны дүн харуулж байна. Иймд едөр тутмын амьдралд тохиолдох бэрхшээлийг даван туулах, байдлыг дүгнэн зөв сонголт хийх, архи, тамхи, хорт зуршилд



автахаас сэргийлэх мэдлэг, дадалтай болгоход чиглэсэн амьдрах ухааны суурь боловсролыг хүүхэд, өсвөр үеийнхэнд эзэмшүүлэх чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хөтөлбөрийг хянан шинэчлэх явдал чухлаар шаардагдаж байна.

1.2.7. Архидан согтуурагчид, архинд донтох өвчтэй хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээний байдал

Архи уун согтуурч биеэ авч явах чадваргүй болсон, хэв журмын зөрчил гаргасны улмаас жилдээ 130000-140000 хүн "эрүүлжүүлэгдэж" байгаа бөгөөд энэ үйл ажиллагаа нь "эрүүл" болгох, эмчлэх замаар хордлогыг нь тайлах гэдэг утгаар бус харин архидан согтуурч хэвийн бус яваа хүнийг гэмт хэрэг, зөрчилд өртөх, амь нас, эрүүл мэндээр хохирохоос сэргийлэх зорилгоор эрхийг нь албадан хязгаарлах байдлаар явагдаж байна.

2002 онд 13028 хүн наркологийн нарийн мэргэжлийн тусламж авч, 2556 хүн "Миннесота" загвар /мэдээлэл, танин мэдэхүйн сургалт, сэтгэл засал/-ын эмчилгээнд хамрагдсан нь өмнөх оныхоос 2,3-2,7 дахин нэмэгджээ. Архинд донтох өвчний улмаас сайн дураараа эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн болон албадан эмчлүүлсэн хүний тоо ч өссөн байна. Тухайлбал, нийслэл дэх наркологийн эмнэлэгт 2002 онд 1261 хүн хэвтэж эмчлүүлсэн нь 2000 оныхой харьцуулахад 2 дахин, Багахангай дахь архидад, мансуурах донтой өвчнийг албадан эмчлэх эмнэлэгт 2002 онд 1137 хүн эмчлүүлсэн нь өмнөх оныхоос 3,2 дахин тус тус нэмэгджээ. Гэвч архаг архичдыг албадан эмчлэх ажиллагаа нь ихэнхдээ компаничилсан шинжтэй, эмнэлгийн орчин нөхцөл нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй, төсөв санхүү хүрэлцэхгүй, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байгаа нь дээр дурдсан эмчилгээ, үйлчилгээний үр дүн, чанар, хүртээмжид муугаар нөлөөлж байна.

Эмчлүүлэгчдийн эмчилгээний үр дүнг батжуулах, дахилтаас сэргийлэх ач холбогдол бүхий олон нийтийн үүсгэл санаачлагаар 1998 онд байгуулагдсан "АА" цуглаанд нийслэлийн 7 дүүрэг, 13 аймагт бүгд 1493 хүн хамрагдаад байгаа хэдий ч орон нутгийн дэмжлэг, мэргэжил арга зүйн удирдлага дутагдалтайгаас эмчилгээнд хүмүүсийг бүрэн хамруулж чадахгүй байна. Тэрчлэн эмчлэгдээд гарсан хүмүүсийг хяналтанд авч хөдөлмөр зохицуулалт хийх, амьдрах чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн нөхөн сэргээх тусламж үйлчилгээ, ажлын байраар хангах явдал хангалтгүй байна.

Архинд донтох өвчин нь удаан хугацааны эмчилгээ, сургалт, хяналт шаардлагатай, өртөг зардал ихтэй, эмчилгээний үр дүн багатай өвчин

болохыг ДЭМБ тогтоожээ. Харин архины асуудалтай хүмүүсийг эрүүл мэндийн анхны тусламжийн түвшинд эрт илрүүлж эмчлэх, эмийн болон сэтгэл заслын амбулатори, стационарын эмчилгээг зохистой хослуулж, тасралтгүй эмчлэх, хяналтанд авах нь архинд донтох өвчтэй болохоос урьдчилан сэргийлэх үр ашгтай арга болох нь дэлхийн олон орны туршлагаар батлагдсан юм. Иймд эрүүл мэндийн суурь тусламжийн түвшинд сум, өрхийн эмнэлгийн үйлчилгээгээр архи хэтрүүлэн хэрэглэгч, архины хамааралтай хүнийг эрт илрүүлж наркологийн нарийн мэргэжлийн эмчилгээнд илгээх, эмчлэгдсэний дараа хяналтанд авах арга хэмжээг манай орны практикт зөв, оновчтой бүтэц, зохион байгуулалттайгаар авч хэрэгжүүлэх нь чухал байна.

Архидан согтуурахаас сэргийлэхэд нийгэм, хамт олны оролцоо хангалтгүй, архины хамааралтай хүний эмчилгээ, хяналт, нөхөн сэргээлт, хөдөлмөр зохицуулалт, нийгмийн халамжийн үйлчилгээ дутагдалтай байсаар байна.

1.3. Тулгамдсан асуудал, хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Нийгэм, эдийн засгийн шилжилт, ажилгүйдэл, ядуурал, байгалийн гамшиг, гэнэтийн осол, гэр бүл, байгууллага, хамт олон, хүмүүсийн хоорондын зүй бус харилцаа, хүчирхийлэл бүхий таагүй орчин зэргээс шалтгаалан иргэдийн сэтгэцийн эрүүл мэнд илүүтэй хаамарч, архидан согтуурах явдал улам бүр газар авч, архины хэрэглээ ба түүнээс үүдэн гарах сөрөг үр дагавар жил ирэх тутам нэмэгдэх хандлагатай байна.

Согтууруулах ундаанд тавих хяналтыг татвар, үнийн бодлогоор зохицуулах явдал хангалтгүй, үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг хавтгайруулан олгож, согтууруулах ундааг ямар ч зөвшөөрөлгүйгээр импортлох болсноос согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт нэмэгдэж, чанарын шаардлага хангахгүй согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ, зэр сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд тавих хяналт сул, хууль зөрчигчдөд авах арга хэмжээ үр нөлөө муутай, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах төсөв, хөрөнгө дутагдалтай, архины хор хөнөөл, архидан согтуурахаас сэргийлэх талаар олон нийт, ялангуяа хүүхэд өсвөр үеийнхний мэдлэг муу, архинд донтох өвчнийг эрт илрүүлэх, хяналт тавих нийгэм, хамт олонд тулгуурласан тусламж үйлчилгээ байхгүй, архины хэрэглээнээс үүдэн гарах хүн амын өвчлөл, нас баралт, хүчирхийлэл, осол гэмтлийн нийгмийн зардал буюу архины үйлдвэрлэлийн эдийн засгийн ашиг ба зардлын үнэлгээ хийгдээгүй, архидан согтуурахаас сэргийлэх, тэмцэх ажилд төрийн болон төрийн бус

байгууллага, олон нийт, гэр бүлийн оролцоо хангалтгүй байна.

Ийнхүү согтууруулах ундааны хэрэглээ нэмэгдэж, хэрэглэгчид нь улам бүр залуужиж, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүний тоо төдийлэн буурахгүй, архианаас үүдэлтэй хүн амын өвчлөл, осол гэмтэл, нас баралт нэмэгдсээр байгаа нь хүний тогтвортой хөгжилд саад болж буй гол хүчин зүйлийн нэг болж, иргэд, айл өрхийн амьдрал, улмаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хохирол учруулж үндэсний аюулгүй байдалд ноцтой сөрөг үр дагаврыг үүсгэж байгаа нь манай нийгмийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Архидан согтуурахын шалтгаан, нөхцөлийг тогтоох зорилгоор цагдаагийн байгууллагаас хийсэн удаа дараагийн судалгаагаар түүнд хамрагдсан хүмүүсийн 57,9–73,3 хувь нь нийгмийн хяналт суларснаас, 23,5-46,8 хувь нь архины үйлдвэр, баар, цэнгээний газар олширсон, архийг чөлөөтэй худалдах болсон, чөлөөт цагийг зүй зохистой өнгөрөөх газаргүй байгаагаас архидан согтуурах явдал ихсэж байна гэж үзжээ.

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс нийслэлийн 3 дүүргийн 15 байгууллага дээр хийсэн судалгаагаар түүнд хамрагдсан хүмүүсийн 57,9–73,3 хувь нь согтууруулах ундааны хэрэглээ, ялангуяа архины хэрэглээг бууруулах шаардлагатай гэсэн хандлагатай байгаа нь энэ чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг олон нийтийн зүгээс дэмжин хамтран ажиллах нийгмийн сэтгэл зүйн таатай уур амьсгал буй болсныг харуулж байна.

Цаашид согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ, хэрэглээнд тавих хууль, хяналтын механизмыг оновчтой, үр өгөөжтэй болгох, согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварыг дэс дараатай нэмэгдүүлэх замаар хүүхэд, өсвөр үеийнхнийг тохиолдлоор сонирхон согтууруулах ундаа хэрэглэхээс сэргийлэх, онцгой албан татвар, гаалийн татварын хувь хэмжээг спиртийн орц, хэмжээ, хатуулаг, чанар, төрлөөр нь ялгавартай, оновчтой тогтоох, пиво, ургамал, жимсний ханд бүхий бага хатуулагтай согтууруулах ундааны дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих, насанд хүрэгчдэд зохистой хэрэглээ төлөвшүүлэх, архидан согтуурснаас хүний эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаар хүн амын мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй хүнийг эрт илрүүлж урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналт тавих эрүүл мэнд, нийгмийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгох, энэ ажилд оролцох төрийн болон төрийн бус байгууллага, аж

ахуйн нэгж, иргэд, гэр бүл, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зэргээр архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх өнөөгийн арга барилыг өөрчлөн шинэ арга, хандлагаар ажиллах шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

2.1. Хөтөлбөрийн зорилго

Согтууруулах ундааны эрэлт хэрэгцээ, нийлүүлэлт, хатуулаг, чанарт тавих хяналтыг сайжруулах замаар хүн амын согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, архидан согтуурснаас хүн амын эрүүл мэнд, нийгэмд учрах сөрөг үр дагаврыг багасгах эрх зүй, эдийн засаг, нийгмийн орчин бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Зорилт

2.2.1 Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ, хэрэглээнд тавих хууль, хяналтын механизмыг оновчтой болгоно;

2.2.2. Архидан согтуурснаас эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаар хүн амын мэдлэг, хандлагыг дээшлүүлэн архидалтгүй аж төрөх зан үйлийг хэвшүүлнэ;

2.2.3. Архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй хүнийг эрт илрүүлж урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналт тавих арга хэмжээг боловсронгуй болгож, хүртээмжийг нэмэгдүүлнэ;

2.2.4. Архины хэрэглээ, түүнээс үүдэн гарах хүн амын өвчлөл, нас баралт, хвчирхийлэл, осол гэмтлийн нийгмийн зардал буюу согтууруулах ундааны үйлдвэрлэлийн эдийн засгийн ашиг, зардлын үнэлгээг судлан тогтоож, авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ;

2.2.5. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, гэр бүл, хамт олны архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг хариуцлагыг тодорхой болгон хамтын ажиллагааг сайжруулна.

2.3. Хугацаа

Хөтөлбөрийг 2003-2012 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат: 2003-2007 он
Хоёрдугаар үе шат: 2008-2012 он

Гурав. Хөтөлбөрийн зорилгод хүрэх зарчим, үйл ажиллагааны чиглэл

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим:

3.1.1. Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих арга хэмжээ нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлтэй уялдсан байна;

3.1.2. Хөтөлбөрийн үйл ажиллагаа нь ДЭМБ болон бусад олон улсын байгууллагын бодлого, чиглэлтэй нийцсэн байх, энэ чиглэлээр тэдгээртэй хамтран ажиллана;

3.1.3. Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг иргэд, гэр бүл, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгууна;

3.1.4. Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үйл ажиллагаа нь архидан согтуурах шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, архидан согтуурснаас нийгэм, эдийн засагт үзүүлж байгаа сөрөг үр дагаврын талаархи судалгаа, нотолгоонд үндэслэгдсэн энгийн, үр ашигтай байна;

3.1.5. Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үйл ажиллагаа нь хүүхэд, өсвөр үеийнхнийг архидан согтуурахаас сэргийлэх, насанд хүрэгсдэд зохистой хэрэглээ төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

3.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.2.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдүгээр зорилгын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.2.1.1. согтууруулах ундааны онцгой албан татвар болон гаалийн татварын хувь, хэмжээг спиртийн орц, хэмжээ, хатуулаг, чанар, төрлөөр нь ялгавартай, оновчтой тогтоох, ливо, ургамал, жимсний ханд бүхий бага хатуулагтай согтууруулах ундааны дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор зохицуулах;

3.2.1.2. согтууруулах ундаанд ногдуулж буй онцгой албан татварын хувь хэмжээг дэс дараатай нэмэгдүүлж хүүхэд, өсвөр үеийнхнийг тохиолдлоор сонирхон согтууруулах ундаа хэрэглэхээс сэргийлэх;

3.2.1.3. согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрлөөр явуулж, тэдгээрт тавих шаардлагыг чангатгах;

3.2.1.4. согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэх цэгийн байршил / сургууль, цэцэрлэг, эмнэлгийн орчин, шатахуун

түгээгүүрийн газар, авто замын дагуу болон аж ахуйн нэгж, байгууллагын доторхи хүнсний мухлаг, цайны газарт худалдахгүй, үйлчлэхгүй байх зэрэг/ , тархалт, худалдах, үйлчлэх цаг хугацааны талаар зохицуулалт хийж, цаг салбарын тоог цөөрүүлэх, согтууруулах ундаагаар үйлчлэхгүй, худалдахгүй өдөр, цагтай болох;

3.2.1.5. согтууруулах ундааны шил, сае, хайрцаг дээр эрүүл мэндийн анхааруулга, хэрэглээний стандарт хэмжээг тавих;

3.2.1.6. согтууруулах ундаа худалдах, худалдан авах, хэрэглэж болох насны доод хязгаарыг шинэчлэн тогтоох;

3.2.1.7. согтууруулах ундааны борлуулалт, хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн зар сурталчилгааны аливаа хэлбэрийг бүрэн хориглох арга хэмжээ авах;

3.2.1.8. согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагаас хүүхэд, өсвөр үеийнхний дунд төрөл бүрийн уралдаан, тэмцээн, сугалаа, таавар зохион байгуулах, соёл, урлагийн арга хэмжээг ивээн тэтгэх, хандив өргөх, аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа, үйлчилгээ явуулах зэргээр дэмжлэг үзүүлэхийг хориглох;

3.2.1.9. согтууруулах ундаа худалдах, үйлдвэрлэх, импортлох, түүгээр үйлчлэх журмыг шинэчлэн мөрдүүлэх.

3.2.1.10. импортын согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг тогтоосон худалдааны техникийн зохицуулалт хийх;

3.2.1.11. спирт, согтууруулах ундааны үйлдвэрийг тоолууржуулж, аттестатчилж байх;

3.2.1.12. онцгой албан татварын тэмдгийн хэвлэлт, олголт, хэрэглэж байгаа байдалд тавих хяналтыг чангатгах;

3.2.1.13. импортын согтууруулах ундааг экспортлогч оронд нь баталгаажуулах, экспортлогч орны тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх механизм бий болгох;

3.2.1.14. согтууруулах ундааны үйлдвэрлэл, импортод тавих хяналтыг стандарт, эрүүл ахуй, чанарын шаардлагыг хангах, зохистой хэрэглээг бүрдүүлэх чиглэлээр өөрчлөн зохион байгуулах;

3.2.1.15. согтууруулах ундааны татвар ногдуулалт, хураалтанд тавих хяналтыг чангатгах;

3.2.1.16.иргэдийн худалдааны бус зориулалтаар улсын хилээр нэг удаа оруулж болох согтууруулах ундааны зөвшөөрөгдөх хэмжээг хянан үзэж шинэчлэн тогтоох;

3.2.1.17.үйлдвэрлэх, импортлох согтууруулах ундааны хатуулгийг бууруулж, чанарыг сайжруулах.

3.2.2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хоёрдугаар зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.2.2.1.хүүхэд, өсвөр үеийнхнийг согтууруулах ундаа хэрэглэхээс зайлсхийх, хэрэглэхгүй байх арга ухаанд сургах, амьдрах ухааны суурь боловсрол эзэмшүүлэх;

3.2.2.2.насанд хүрэгчдийн дунд согтууруулах ундааны зохистой хэрэглээг төлөвшүүлэх;

3.2.2.3.согтууруулах ундаа худалддаггүй, хэрэглэдэггүй "Эрүүл мэндийг дэмжигч" орчинг бий болгох талаар бүх шатны боловсролын байгууллага, ахуйн нэгж, албан байгууллагын хамт олны идэвхи санаачлагыг өрнүүлэх, дэмжлэг үзүүлэх, урамшуулах;

3.2.2.4.аливаа баяр ёслол, тэмдэглэлт үйл явдлыг архигүй тэмдэглэх хөдөлгөөн өрнүүлж, залуучуудын чөлөөт цагаа зүй зохистой өнгөрүүлэх тааламжтай орчинг бүрдүүлэх;

3.2.2.5.архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг, архины асуудалтай хүнд үзүүлдэг тусламж үйлчилгээ, архины зохистой, соёлтой хэрэглээний талаар хүн амын мэдлэг, хандлага, зан үйлийн өөрчлөлтийг судалж мэдээлэх, холбогдох арга хэмжээг авч байх.

3.2.3. Хөтөлбөрийн үйл ажиллагааны гуравдугаар зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.2.3.1. архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй хүнийг эрт илрүүлж эмчлүүлэх, хяналтад авах арга хэмжээг эрүүл мэндийн суурь тусламжийн хүрээнд зохион байгуулах;

3.2.3.2.архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй хүн, түүний гэр бүлийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэх, энэ чиглэлээр албан байгууллага, хамт олны оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх;

3.2.3.3.архины улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүст хөдөлмөр зохицуулалт хийх, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээг сайжруулах;

3.2.3.4.архины хамаарлаас гарсан хувчсийн сэтгэц-нийгмийн чадварыг нөхөн сэргээх сургалт явуулах, ажлын байраар хангах;

3.2.3.5.согтууруулах ундаанд хордсон үед үзүүлэх хордлого тайлах болон архинд донтох өвчний үед үзүүлэх наркологийн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах;

3.2.3.6.архидан согтуурсны улмаас гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлж байгаа ялтнуудыг сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулах;

3.2.3.7. архи хэтрүүлэн хэрэглээний улмаас өөрийн үйлдлээ удирдан хянах чадваргүй болсон этгээдийг албадан эрүүлжүүлж, өөрийн нь болон бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдэх, осол гэмтэлд өртөхөөс сэргийлж буй үйл ажиллагааны арга хэлбэр, үйлчилгээ, нөхцөлийг боловсронгуй болгох;

3.2.3.8.архинд донтох өвчнийг эмчлэх дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн аргыг харьцуулан судлах замаар хэрэгжүүлэх.

3.2.4. Хөтөлбөрийн үйл ажиллагааны дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.2.4.1. архины бүртгэгдээгүй хэрэглээг судлах;

3.2.4.2.архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг, архины асуудалтай хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээ, архины зохистой, соёлтой хэрэглээний талаар хүн амын мэдлэг, хандлага, зан үйлийн өөрчлөлтийг судлах;

3.2.4.3.архины үйлдвэрлэл, борлуулалтын эдийн засгийн ашиг ба хэрэглээнээс үүдэн гарах өвчлөл, нас баралт, хүчирхийлэл, осол гэмтлийн нийгмийн зардлын судалгаа, үнэлгээ хийх;

3.2.4.4. архинд донтох өвчний үед үзүүлж буй эмчилгээний үр дүнг судлах;

3.2.4.5.архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үйл ажиллагааны талаар мэдээллийн сантай болох.

3.2.5. Хөтөлбөрийн үйл ажиллагааны тавдугаар зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн болон



төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, гэр бүл, хамт олон дараахь үүрэг хүлээнэ:

3.2.5.1. Монгол Улсын Засгийн газар

1/хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улс, орон нутгийн төсөвт тусгах;

2/согтууруулах ундааны үйлдвэрлэл, импортод тавих хяналтыг татвар, үнийн бодлогоор зохицуулах;

3/хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоо, идэвхи санваачлагыг дэмжих.

3.2.5.2. Хууль зүй, дотоод хэргийн яам

1/Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль, тогтоомжийг боловсронгуй болгох;

2/хууль дүрэм, тогтоол шийдвэрийн биелэлтийг улсын хэмжээнд хангах талаар төрийн захиргааны байгууллагын үндсэн үйл ажиллагааг чиглүүтж удирдлага, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/архидан согтуурсны улмаас биеэ авч явах чадваргүй болсон хүнийг албадан эрүүлжүүлэх байрны нөхцөл, үйлчилгээг сайжруулах;

4/архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй хүнд албадан эмчилгээ хийх байгууллагын бүтэц, зохион байгуулалт, эрүүл ахуйн нөхцөл, эмч мэргэжилтний хангамжийг сайжруулах;

5/Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль, тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах, архидалтаас үүдэн гарсан гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүн шинжилгээ хийж байх;

6/согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд оногдуулах ял шийтгэл, захиргааны арга хэмжээг чангатгах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шуурхай байдлыг хангах

3.2.5.3. Санхүү, эдийн засгийн яам

1/хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн

чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байх;

2/хөтөлбөрийн хүрээнд гадаад, дотоодын байгууллага, хандивлагчидтай хамтран дэд хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх талаар дэмжлэг үзүүлэх;

3/согтууруулах ундааны үйлдвэрлэлт, борлуулалтын эдийн засгийн ашиг болон хэрэглээнээс үүдэн гаргах өвчлөл, нас баралт, хүчирхийлэл, осол гэмтлийн нийгмийн зардлын үнэлгээ хийх

3.2.5.4. Гадаад хэргийн яам

1/ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ДЭМБ, НҮБ-ын төрөлжсөн байгууллага, хандивлагч орон болон олон улсын бусад байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх.

3.2.5.5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

1/хүүхэд, өсвөр үеийнхэнд амьдрах ухааны суурь боловсрол /зөв сонголт хийх, шийдвэр гаргах, бүтэцлээр сэтгэх, шүүмжлэлтэй хандах, сэтгэл хөдлөлөө барих, бүхмидлаа тайлах, харилцааны эв дүй/ эзэмшүүлэх сургалт явуулж, тэдэнд согтууруулах ундаа хэрэглэхээс татгалзах, бусдын дарамт нөлөөнд автахгүй байх, чөлөөт цагаа эв өнгөрүүлэх, эв сонголт хийх мэдлэг, хандлага, дадал төлөвшүүлэх, энэ чиглэлээр бүх шатны боловсролын байгууллагын албан ба албан бус сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсронгуй болгох, энэ сэдвээр багш, сурган хүмүүжүүлэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авч, хэрэгжигтийг зохион байгуулах;

2/архидан согтуурснаас нийгэм, эдийн засаг, хувь хүний ёс зүй, бие сэтгэгдэл учруулах хор уршгийн талаар тодорхой дээ дараалалтай мэдлэг, хандлага төлөвшүүлэх чиглэлээр бүх шатны боловсролын байгууллагын сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсронгуй болгох;

3/багш, эцэг, эхчүүдэд хүүхэд, өсвөр үеийнхэнд эв үлгэр дууриалал үзүүлэх, хүүхдийн нас, сэтгэл зүй, бие бялдрын онцлог, харилцааны соёлын талаар сургалт явуулж, гэр бүл, сургуулийг хүчирхийллээс ангид байлгах талаар олон талт ажил зохиох;

4/бүх шатны боловсролын байгууллагад архи, тамхи бусад хорт зуршлаас ангид байх орчин бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх;



5/сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн хамруулах, сургууль завсардахаас сэргийлэх, завсардсан хүүхдийг сургалтад хамруулах, хичээлийн чөлөөт цагаар хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл зан үйл төлөвшүүлэхэд үр нөлөө үзүүлэхүйц биеийн тамир, спорт, соёл, урлагийн төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, нөхцөл боломжоор хангах, эдгээр арга хэмжээнд хамрагдах хүүхдийн тоог өргөжүүлэх;

6/оюутан, сурагчдын дунд архидаан согтуурахын хор уршиг, түүнээс сэргийлэх, ардын уламжлалт ёс заншлын талаар хичээлээс гадуур цуврал хичээл, уулзалт ярилцлага, бага хурал, мэтгэлцэн, үзэсгэлэн, ханын сонин, зураг, зохион бичлэгийн уралдаан зохион байгуулах, сургуулийн дотоод, гадаад орчинд архины эсрэг сурталчилгааны самбар, санамж, зурагт хуудас байрлуулах зэргээр хүмүүжлийн ажлыг тогтмолжуулах;

7/ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги, тусгай мэргэжлийн болон их, дээд сургуулиудын оюутан, сурагчдын дунд судалгаа явуулж дүгнэлт хийх үндсэн дээр баримт нотолгоонд түшиглэн шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж байх;

8/архины хор нөлөө, архидаан согтуурснаас үүдэн гарах сөрөг үр дагавар, түүнээс сэргийлэх, архины зохистой, соёлтой хэрэглээний талаар хүн амын мэдлэг, хандлага, зан үйлийн өөрчлөлт, согтууруулах ундааны үйлдвэрлэлт, борлуулалтын эдийн засгийн ашиг болон хэрэглээнээс үүдэн гарах өвчлөл, нас баралт, хвчирхийлэл, осол гэмтлийн нийгмийн зардлыг тооцсон судалгааны ажлыг үйл ажиллагааныхаа хүрээнд багтаан төлөвлөж дэмжлэг үзүүлэх;

9/бүх шатны боловсролын байгууллагын хичээлийн болон дотуур байрны гадаад, дотоод орчныг архигүй орчин байлгах, сургууль төгсгалтийн болон хонхны баяр, багш нарын өдөрлөг, сургуулийн ой зэрэг тэмдэглэлт үйл явдлыг согтууруулах ундаагүй тэмдэглэж занших;

10/архидаан согтуурахын хор уршигийг таниулсан соёл, урлаг, уран сайхны зохиол бүтээл, нийтлэл, нэвтрүүлгийн тоо, төрлийг нэмэгдүүлэх.

3.2.5.6. Батлан хамгаалах яам

1/цэргийн алба хаагчдад архидаан согтуурснаас нийгэм, эдийн засаг, хувь хүний эрүүл мэнд, ёс зүй, бие сэтгэцэд учруулах хор уршиг, түүнээс сэргийлэх талаар тодорхой дэс

дараалалтай мэдлэг, хандлага төлөвшүүлэх чиглэлээр сургалт явуулах.

3.2.5.7. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам

1/ажлын байранд согтууруулах ундаа худалдахгүй, хэрэглэхгүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2/ажиллагчдад архидаан согтуурснаас нийгэм, эдийн засаг, хувь хүний эрүүл мэнд, ёс зүй, бие сэтгэцэд учруулах хор уршигийн талаар тодорхой дэс дараатай мэдлэг, хандлага төлөвшүүлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах;

3/архины асуудалтай хүмүүсийг ажлын байраар хангах, хөдөлмөр зохицуулалт хийх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээг өргөжүүлэх;

4/архидаан согтуурснаас хөдөлмөрийн бүтээмж, хамт олны харилцаа, үйлдвэрлэлийн осол гэмтэл, ажил таслалт, боловсон хүчний тогтвор суурьшилд үзүүлж буй сөрөг үр дагаврыг судлан холбогдох арга хэмжээ авч ажиллах;

5/эмзэг бүлгийн хүн амын дунд судалгаа явуулж, баримт нотолгоонд түшиглэн шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж байх.

3.2.5.8. Үйлдвэр, худалдааны яам

1/согтууруулах ундаа худалдах, импортлох, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох нийтлэг журмыг боловсруулж мөрдүүлэх, тавих шаардлагыг өндөржүүлэх;

2/спирт, согтууруулах ундааны үйлдвэрийг тоолууржуулж, холбогдох байгууллагатай хамтран аттестатчилж байх;

3/бөөний болон хүнсний худалдааны төв, хүнсний дэлгүүр, мухлаг, зоогийн газар, баар, рестораны үйл ажиллагааг холбогдох хууль, улсын стандарт, журамд нийцэж байгаа эсэхэд хийх шалгалтыг тогтмолжуулж, бөөний худалдааг зөвхөн агуулахаас явуулах, бөөнөөр худалдах бүрт Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөс олгодог тохирлын гэрчилгээг дагалдуулж хэвшүүлэх, хяналт тавих;

4/импортын согтууруулах ундаанд техникийн зохицуулалт хийж, импортлохдоо дээжийг нь стандартчилал, хэмжил зүйн болон



эрүүл ахуйн мэргэжлийн хяналтын байгууллагаар заавал баталгаажуулж байх журмыг мөрдүүлэх;

5/согтууруулах ундааг зөвхөн олон улсын боомтоор импортлож байх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх;

6/согтууруулах ундааны импортод тавих хяналтыг стандарт, эрүүл ахуй, чанарын шаардлагыг хангах, зохистой хэрэглээг буй болгох /хатуулгийг бууруулах, эрүүл мэндийн сануулгатай байх, ямар стандарт агуулагдаж байгааг бичих зэрэг/ чиглэлээр өөрчлөн зохион байгуулах.

3.2.5.9. Хүнс, хөдөө аж ахуйн яам

1/аж ахуйн нэгжид согтууруулах ундаа үйлдвэрлэх зөвшөөрөл олгох нөхцөл, журмыг хянан үзэж, хязгаарлалт, зохицуулалт хийх, үйлдвэрлэл шинээр эрхлэхэд тавих хяналтыг сайжруулах;

2/согтууруулах ундааны үйлдвэрлэлийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, технологийн горим, түүхий эд, бүтээгдэхүүний чанарт тавих хяналтыг сайжруулж, технологийн урсгал шугамыг тоолууржуулж, аттестатчилах;

3/спиртийн үйлдвэрлэл, хуваарилалт, зарцуулалтад тавих хяналтыг боловсронгуй болгох;

4/согтууруулах ундааны үйлдвэрлэлийн төслийн материалд дүгнэлт өгөх, согтууруулах ундааны хэрэглээг судлан тогтоож байх;

5/согтууруулах ундааны үйлдвэрлэлд дэвшилтэт технологи, техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах.

3.2.5.10. Эрүүл мэндийн яам

1/архинд донтох өвчнийг эрүүл мэндийн суурь тусламжийн хүрээнд эрт илрүүлэх, эмчлэгдсэн хүнийг хяналтанд авах арга хэмжээг зохион байгуулах;

2/согтууруулах ундааны хор нөлөө, архинд донтох өвчний талаар хүүхэд, залуучууд, нийт хүн амын дунд явуулах эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, энэ чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах;

3/наркологиан албыг бэхжүүлж, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4/архинд донтох өвчнийг эрт илрүүлэх, эмчлэх, нөхөн сэргээх талаар эмч, эмнэлгийн ажилтан бэлтгэдэг сургуулийн төгсөлтийн өмнөх болон дарваах сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох;

5/архинд донтох өвчний үед үзүүлж буй эмчилгээний үр дүнг судлах;

6/архинд донтох өвчинг эрт илрүүлэх, эмчлэх, урьдчилан сэргийлэх талаар аргачлал, удирдамж боловсруулан эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн ажилтнуудад мөрдүүлэх;

7/согтууруулах ундааны эрүүл мэндэд сөрөг нөлөөлөхгүй нэг удаагийн хэрэглээний үндэсний стандарт хэмжээг судлан тогтоох.

3.2.5.11. Улсын гаалийн өрөнхий газар

1/улсын хилээр оруулах болон дамжин өнгөрүүлэх согтууруулах ундаанд тавих хяналтыг чангатган хууль бус спирт, согтууруулах ундаа оруулах асуудлыг таслан зогсоох талаар үр нөлөө бүхий арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2/иргэдийн худалдааны бус зориулалтаар улсын хилээр нэг удаа оруулж болох согтууруулах ундааны зөвшөөрөгдөх хэмжээг тогтоох;

3/гадаад улс орноос гэрээ, захиалгаар авч байгаа бүх төрлийн согтууруулах ундааг нэвтрүүлэх хилийн боомтыг цөөлөх, зөвхөн олон улсын боомтоор импортлож байх асуудлыг холбогдох яам, байгууллагатай хамтран шийдвэрлэх;

4/гаалийн баталгаат агуулахын эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, шаардлагатай тоног, төхөөрөмжөөр хангах.

3.2.5.12. Цагдаагийн өрөнхий газар

1/согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдийг эрт илрүүлэхэд чиглэсэн үзлэгийг тогтмолжуулж, хүлээлгэх хариуцлагыг чангатгах;

2/архидан согтуурсны улмаас байнга эрх зүйн зөрчил гаргагчдын судалгааг гаргаж гэр бүл, хамт олонтой нь хамтран ажиллах;



3/архидан согтуурсны улмаас хэвийн бус яваа этгээдийг албадан эрүүгжүүлэх, сайн дурын эмчилгээнээс татгалзсан архинд донтох өвчтэй хүнийг албадан эмчилгээнд хамруулах ажилд өөрийн үйл ажиллагааны хүрээнд оролцох;

4/гудамж талбай, олон нийтийн үйлчилгээний газарт хийх хяналт шалгалт, эргүүлийг тогтмолжуулах;

5/хууль бусаар болон стандартын бус архи худалдсан, үйлчилсэн, насанд хүрээгүй хүнийг уруу татан архи уулгасан этгээдийг илрүүлэн тухай бүр арга хэмжээ авч байх;

6/архидан согтуурсны улмаас удаа дараа хэв журам зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн, тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдийг тухай бүр сэтгэц-наркологиин эмчийн үзлэг, шинжилгээнд оруулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

7/согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийх.

3.2.5.13. Улсын мэргэжлийн хяналтын газар

1/Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

2/согтууруулах ундааны үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалтын технологи, стандарт, чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хянан холбогдох арга хэмжээг авч байх;

3/согтууруулах ундаа оруулдаг хилийн боомтыг бүтээгдэхүүний чанар, аюулгүйн үзүүлэлт тодорхойлдог лабораторитой болгож, стандартын бус согтууруулах ундаанд тавих хяналтыг сайжруулах;

4/согтууруулах ундааны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад техник, технологи, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

5/архидан согтуурсан болон архинд донтох өвчтэй этгээдэд хууль эрх зүй, эмнэлгийн тусламж үзүүлж буй байгууллагын эрүүл ахуйн нөхцөл, эмчилгээний чанарыг сайжруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих.

3.2.5.14. Үндэсний татварын ерөнхий газар

1/онцгой албан татварын тэмдгийн хэвлэлт, олголт, хэрэглэж байгаа байдалд тавих хяналтыг чангатгах;

2/согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татвар болон гаалийн татварын хувь хэмжээг спиртийн орц, хэмжээ, хатуулаг, чанар, терлеер нь ялгавартай, оновчтой тогтоох асуудлыг шийдвэрлэх, татвар ногдуулалт, хураалтанд тавих хяналтыг чангатгах.

3.2.5.15. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв

1/дотоодод үйлдвэрлэж байгаа согтууруулах ундааг чанарын баталгаажуулалтад бүрэн хамруулж, тохирлын гэрчилгээ олгож байх;

2/импортын согтууруулах ундааг экспортлогч оронд нь баталгаажуулах, экспортлогч орны тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх механизм буй болгох;

3/согтууруулах ундааны стандартыг хатуулийг бууруулж, чанарыг сайжруулах чиглэлээр шинэчлэх.

3.2.5.16. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга

1/ хөтөлбөрийн зарчим, үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн орон нутгийн онцлог, тулгамдсан асуудалд тулгуурласан дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

2/хүүхэд, өсвөр үеийнхнийг архидан согтуурахаас сэргүүлэх, насанд хүрэгчдийн дунд зохистой хэрэгсээ төлөвшүүлэх зорилгоор архидан согтуурснаас хүний эрүүл мэнд, гэр бүл, нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаар уламжлалт ёс заншил, эрүүл мэнд, хууль эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааг дээдараатай, байнга зохион байгуулж, энэ талаар хүн амын мэдлэг, хандлага, дадлын түвшинг тогтоох судалгаа тандалт хийн шаардлагатай арга хэмжээ авч ажиллах;

3/согтууруулах ундаа худалддаг / үйлчилдэг/ цэгийн тоог цөөрүүлэх, эрүүл мэнд, хүүхэд, залуучууд, боловсролын байгууллагын орчинд согтууруулах ундааг худалдахгүй / үйлчлэхгүй/ байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4/стандартын шаардлага хангасан согтууруулах ундааг тодорхой цэгт борлуулах /үйлчлэх/. архи худалдааггүй, үйлчилдэггүй, хэрэглэдэггүй сар, өдөр, цагтай болох шийдвэр гарган хэрэгжилтийг хянах, үр дүнг тооцох;

5/архи хэрэглэх уламжлалт ёс заншлыг хэвшүүлэх, аливаа баяр ёслол, тэмдэглэлт үйл явдлыг архигүй тэмдэглэх талаар нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд тодорхой зорилт тавьж хэрэгжүүлэх;

6/архи хэрэглэдэггүй хүмүүсийн туршлага, зөвлөгөөг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг тогтмолжуулах, тэдний оролцоотойгоор архидан согтуурахаас сэргийлэх олон нийтийн байгууллага байгуулж ажиллах үүсгэл санаачлагыг бүх талаар дэмжих;

7/тусгай аргачлалын дагуу нутаг дэвсгэрийнхээ нийт хүн амыг архи хэрэглэх байдлаар нь бүлэглэн тус бүрд нь тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх, архийг байнга хэтрүүлэн хэрэглэдэг, согтуугаар хэрэг зөрчилд ордог болон архинд донтох өвчтэй хүмүүсийн судалгааг гарган мэргэжлийн байгууллагатай хамтран тусгай хөтөлбөрөөр урьдчилан сэргийлэх, эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, энэ чиглэлээр мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнд дэмжлэг, тусалцаа үзүүлэх;

8/архинд донтох өвчтэй хүнийг сайн дураар нь хаяггүй эмчилгээнд хамруулах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд албадан эмчлэх ажлыг зохион байгуулах, архинаас гарах эмчилгээ хийлгэсэн хүмүүсийн ахуй амьдралд туслах, ажлын байраар хангах арга хэмжээ авч байх;

9/архидан согтуурахаас сэргийлэх талаар тодорхой ажил зохион үр дүнд хүрсэн байгууллага, хамт олонд дэмжлэг үзүүлэх, тэдний үйл ажиллагааг сурталчлах, урамшуулах;

10/байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дүгнэхдээ архидан согтуурахаас сэргийлэх талаар хийсэн ажил, түүний үр дүнг нэг үзүүлэлт болгон сайн ажилласан байгууллага, хамт олныг дэмжин урамшуулж байх;

11/согтууруулах ундааны үйлдвэрлэл нь тухайн орон нутгийн төсөв бүрдүүлэх арга зам болж байгаа одоогийн практикийг өөрчлөн өөр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг дэмжсэн бодлогыг дэс дараатай авч хэрэгжүүлэх.

3.2.5.17. Хэвлэл мэдээллийн байгууллага

1/архидан согтуурахаас нийгэм, эдийн засаг, хувь хүний ёс зүй, бие, сэтгэцэд учрах хор уршгийн талаар нийт хүн ам, ялангуяа хүүхэд өсвөр үеийнхэнд тодорхой дэс дараатай мэдлэг, хандлага, зөв зан үйлийг эзэмшүүлэхэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгааг нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөртөө тусгах, цагийг нэмэгдүүлэх, захиалагчдад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх;

2/хүний эрүүл мэндэд хортой согтууруулах ундааны хэрэглээг дэмжин борлуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зар сурталчилгааг радио, телевизээр нэвтрүүлэхгүй, хэвлэл /сонин, сэтгүүл/-д нийтлэхгүй, санамж, зурагт хуудас, гудамжны самбаруар сурталчлахгүй байх. хүүдсийн эрүүл мэндэд ашиг тустай хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгааг дэмжих бодлого баримталж ажиллах;

3/архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний болон орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиож буй ажлын ололт, дутагдлыг тухай бүр нийтэд сурталчилж байх.

3.2.5.18. Аж ахуйн нэгж, байгууллага

1/архидан согтуурахаас сэргийлэх, зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар ажиллагчдын мэдлэг, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохиох, энэ талаар амжилт олж байгаа нэгж, ажилтанг дэмжих, сурталчлах, тодорхой урамшуулал бий болгох;

2/архидан согтуурахаас нөлөөлөх орчин нөхцөл, сөрөг хүчин зүйлийг арилгаж, байгууллага, хамт олны дотор зөрөг уур амьсгал, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх талаар төлөвлөн ажиллах;

3/ ажиллагчдынхаа зан үйлийг судлан хамт олны чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх талаар тодорхой төлөвлөгөөтэй ажиллаж биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, урлаг соёлын арга хэмжээ зохион байгуулж байх;

4/ажлын байранд архи худалдахгүй, хэрэглэхгүй байх талаар тусгай журам гаргаж, хяналт тавьж ажиллах;

5/тусгай аргачлалын дагуу нийт ажиллагчдыг архи хэрэглэх байдлаар нь бүлэглэн тус бүрд нь тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх, архийг байнга хэтрүүлэн хэрэглэдэг, согтуугаар хэрэг, зөрчилд холбогддог болон архинд донтох өвчтэй хүмүүсийн судалгааг гарган мэргэжлийн байгууллагатай хамтран тусгай хөтөлбөрөөр эмчилгээ, нөхөн сэргээх арга хэмжээнд хамруулах;

6/архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохиож буй арга хэмжээнд идэвхитэй оролцох, боломж нөхцөлөөр хангах, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлэх;

7/архины хамаарлын улмаас эмчилгээ хийлгэсэн хүнийг ажлаа үргэлжлүүлэн хийх, хөдөлмөрийн чадварт нь тохирох ажилд авч ажиллуулах;

8/архины асуудалтай хүн, түүний гэр бүлд дэмжлэг үзүүлэх, хууль эрх зүй, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах;

9/архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг тооцож, жил бүрийн төсөвтөө тусгах, эрүүл мэндийн болон эдийн засгийн үр ашгийг тооцож хэвших.

3.2.5.19. Төрийн бус байгууллагууд

1/хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд өөрийн үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн оролцох, бусад байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх.

3.2.5.20. Иргэн, гэр бүл, олон нийт

1/иргэн бүр архины хор уршгийн талаар зохих мэдлэгтэй болж үр хүүхэд, гэр бүлийнхэндээ тайлбарлан таниулах, хүүхэд, залуучуудыг багаас нь эрүүл амьдрах ухаанд сургах;

2/архины асуудалтай хүн, түүний гэр бүлд мэргэжлийн байгууллага, хүмүүсээс хууль эрх зүй, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, олон нийтийн зүгээс энэ чиглэлээр тусалцаа, дэмжлэг үзүүлэх;

3/насанд хүрэгчид, эцэг, эхчүүд согтууруулах ундааг зүй зохистой хэрэглэх уламжлалт зан үйлээ сэргээн хэвшүүлэх, хүүхэд, залуучуудад зөв үлгэр дууриалал үзүүлэх;

4/холбогдох хууль тогтоомжийн биелэлт, хөтөлбөрийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавих.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

4.1.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд Монгол Улсад гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл эрхэлнэ.

4.1.2.Зөвлөл нь үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавих бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлыг жил бүр нэгтгэн дүгнэж Улсын Их Хуралд танилцуулж байна.

4.1.3.Орон нутагт үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар ахлуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл гүйцэтгэнэ.

4.1.4.Яам, Засгийн газрын агентлаг, хууль хяналт, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагад эл үүргийг тэдгээрийн удирдлагын шийдвэрээр томилогдсон салбар зөвлөл хариуцна.

4.2 Хөтөлбөрийн санхүүжилт

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ.

4.2.1 иргэд, төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, түүнчлэн олон улсын болон гадаадын байгууллага, иргэд, харьяалалгүй хүнээс үзүүлсэн хандив, тусламжийн хөрөнгө;

4.2.2. Монгол Улсын хууль тогтоомжид үл харшлах бусад орлого.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

5.1 Хяналт үнэлгээ

а/Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлт дүгнэлт өгөх, хөтөлбөрийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх асуудлаар санал боловсруулах ажлыг Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл Хууль зүй, дотоод хэргийн яам болон Эрүүл, мэндийн яамтай хамтран гүйцэтгэнэ;

б/Орон нутагт үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх ажлыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга, аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, мэргэжлийн хяналтын албадтай хамтран гүйцэтгэнэ.

5.2. Хөтөлбөрийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

5.2.1. Согтууруулах ундааны эрэлт хэрэгцээ, нийлүүлэлтэд тавих хяналтын үзүүлэлт

№	шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт (2003 он)	Завсрын үзүүлэлт (2007 он)	Эцсийн үзүүлэлт (2012 он)
1.	согтууруулах ундаа худалддаггүй, хэрэглэдэггүй сар, өдөр, цагтай болсон аймаг, сумын тоо	Нийслэл хот, 12 аймагт согтууруулах ундаа худалддаггүй, хэрэглэдэггүй сар, өдөртэй болсон	1/Бүх аймагт согтууруулах ундаа худалддаггүй, хэрэглэдэггүй өдөртэй болно 2/худалдаа, үйлчилгээний цагийн хязгаарлалт хэвшсэн байна	согтууруулах ундаа худалддаггүй, хэрэглэдэггүй сар, өдөр, цагийг нэмэгдүүлнэ
2.	согтууруулах ундааг худалдах цагийн тоо	3530	1/4-ээр цөөрүүлнэ	1/3-ээр цөөрүүлнэ
3.	согтууруулах ундаагаар үйлчилдэг цагийн тоо	1635	1/4-ээр цөөрүүлнэ	1/3-ээр цөөрүүлнэ
4.	согтууруулах ундааг хэрэглэж болох насны доод хязгаар	18 нас	21нас	21нас
5.	согтууруулах ундааны зар сурталчилгааны хориг, хязгаарлалт	хуулийн хэрэгжилт муу	Бүрэн хориглоно	
6.	согтууруулах ундааны үйлдвэрлэлд тусгай зөвшөөрөл олгох	зөвшөөрлийг олноор олгож байна.	зөвшөөрөл олгох журмыг шинэчлэн шалгуур үзүүлэлтийг гарган зөвшөөрлийг 1/4-ээр цөөрүүлнэ	үйлдвэрлэлд олгох зөвшөөрлийг 1/3-ээр цөөрүүлнэ
7.	согтууруулах ундааны шил, сав, хайрцаг дээр эрүүл мэндийн анхааруулга хэрэглэдэг эсэх	үгүй	Эрүүл мэндийн анхааруулгатай болно	
8.	согтууруулах ундааны үйлдвэрлэлд тавих хяналт, түүний үр дүн	20,9% нь чанар аюулгүйн шаардлагыг хангаж байна, 96,7% нь зөвшөөрөлтэй, 18,3% нь хууль бус үйл ажиллагаа явуулж байна.	89,0% хүртэл сайжруулна, 100 % зөвшөөрөлтэй болно	99,9% хүртэл сайжруулна
9.	согтууруулах ундааны импортод тавих хяналт, түүний үр дүн	38,7% нь Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн баталгаажуулалт ад хамрагдсан.	80 %	100%
10.	согтууруулах ундааны борлуулалтад тавих хяналт, түүний үр дүн	30% тохирлын гэрчилгээ, чанарын баталгаатай	85%	100%

5.2.2. Архидан согтуурахаас сэргийлэх талаар явуулсан сургалт, сурталчилгааны ажлын үзүүлэлт

11.*	согтууруулах ундааны хор хөнөөл, зохистой хэрэглээний талаар олон нийтийн мэдлэгийн түвшин	хор хөнөөлийн талаар : сайн 19,3% дунд 49,4% хангалтгүй 12,2% огт мэдэхгүй 19,1% зохистой хэрэглэх талаар 0	хор хөнөөлийн талаар : 50,0 % 28,0 % 11,1 % 10,9 % зохистой хэрэглэх талаар 60%-д хүргэнэ	хор хөнөөлийн талаар : 68,7 % 31,3%- 0 0 зохистой хэрэглэх талаар 90%-д хүргэнэ
12.*	архидан согтуурахаас сэргийлэх, эмчилгээ хийлгэх талаар зөвлө-гөө, тусламж авч болох байгууллагын талаар олон нийтийн мэдлэгийн түвшин	Түвшинг тогтооно	80 %-д хүргэнэ	100 %-д хүргэнэ

5.2.3. Согтууруулах ундааны хэрэглээний үзүүлэлт

13.*	нэг хүнд ногдох бүртгэгдсэн согтууруулах ундааны хэрэглээний бууралт	9,03 литр архи (38 градус) /жил бүр/	1 литрээр багасгана	2 литрээр багасгана
------	--	--------------------------------------	---------------------	---------------------

5.2.4. Эрүүл мэндийн үзүүлэлт / жил бүр /

14**	архидан согтуурсны улмаас зам тээврийн осолд өртөж тохиолдсон нас баралтын бууралт/хувиар /	10000-д 0,04	0,005–аар бууруулна	0,01–ээр бууруулна
15**	архидан согтуурсны улмаас гаднын нөлөө, гэмтэл, хордлогод өр-төж тохиолдсон нас баралтын бууралт /хувиар/	2002 онд ослын нийт нас баралтын 52,5% / ГССЗКЭ/	10 % бууруулна	15 % бууруулна
16	архины хордлогоор нас барсан тохиолдлын эзлэх хувийн жин	хордлогын төвд 4 /50%/	25% бууруулна	50% бууруулна
17	осол, гэмтлийн улмаас /архитай холбоотой/ эмнэлэгт хэвтсэн хүний тоо	2002 онд нийт хэвтсэн хүний 9,4% /ГССЗКЭ/	1,5% бууруулна	2,0% бууруулна

18.	архинд донтох өвчтэй хүний тоо	10000-д 6,4 /СЭМСТ/	0,7-оор бууруулна	1,4-өөр бууруулна
19.*	наркологийн анхан шатны тусламж үзүүлдэг сумын болон өрхийн эмнэлгийн тоо /хувиар/	0	60%	100%
20.*	сум, өрхийн эмнэл- гээр наркологийн анхны тусламж авсан иргэдийн тоо /хувиар/	0	30%	60%

5.2.5. Нийгэм, орчны үзүүлэлт

21 *	эрүүлжүүлэгдсэн хүний тоо	114,1 мянга	15%-иар бууруулна	25%-иар бууруулна
22*	согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн хувь	19,3%	2,5 %-иар бууруулна	4 %-иар бууруулна
23	архидан согтуурахаас сэргийлэх хөтөлбөр- тэй аймаг, хот, сум, дүүргийн тоо,	аймаг, нийслэл, сум, дүүрэгт бие даасан хөтөлбөр байхгүй	аймаг, нийсл- лэл, сум, дүүрэг хөтөлбөртэй болно	Хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлнэ
24.*	эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр, төслийн хүрээнд архидан согтуурахаас сэргий- лэх дэд хөтөлбөр хэрэгжүүлдэг 50-иас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, бай- гууллагын тоо /хувиар/	7 аж ахуйн нэгж, байгууллага	аж ахуйн нэгж, байгууллагын 60% архидан согтуурахаас сэргийлэх дэд хөтөлбөртэй болно	аж ахуйн нэгж, байгууллага бүр архидан согтуу- рахаас сэргий- лэх дэд хөтөл- бөртэй болно
25 *	архидан согтуурахаас сэргийлэх талаар су- рагчдад шаардлагатай мэдлэг, дадал олгож буй /тухайн сургуу- лийн хэрэгжүүлж буй эрүүл мэндийн хөтөл-бөрт нэмэлт байдлаар оруулна/ЕБС-ийн тоо тэдгээрт суралцаг- садын тоо /хувиар/	5% /40 сургууль/	80%	100%

Тайлбар:

* нийтлэг хэрэглэдэг үзүүлэлт

** илүү нийтлэг хэрэглэдэг үзүүлэлт

Зургаа. Хүлээгдэж буй үр дүн

6.1. Ойрын үр дүн /2003-2007 он/

6.1.1. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд тавих хяналт сайжирч, хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэнэ.

6.1.2. Архидан согтуурахаас сэргийлэх, зохистой хэрэглэх талаар олон нийтийн мэдлэг, хандлагын түвшин дээшлэн архидан согтуурахаас сэргийлэхэд чиглэсэн идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг хамт олон, байгууллагын тоо нэмэгдэнэ.

6.1.3. Архины асуудалтай хүмүүст урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналтанд авах анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлдэг сум, өрхийн эмнэлэг, эмч, эмнэлгийн ажилтны эзлэх хувийн жин нэмэгдэнэ.

6.1.4. Архины хэрэглээ, түүнээс үүдэн гарах хүн амын өвчлөл, нас баралт, хүчирхийлэл, осол гэмтлийн нийгмийн зардал буюу согтууруулах ундааны үйлдвэрлэлийн эдийн засгийн ашиг, зардлын үнэлгээ хийгдсэн байна.

6.1.5. Архидан согтуурахтай тэмцэх, сэргийлэх талаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, гэр бүл, хамт олны үүрэг хариуцлага дээшлэн хамтын ажиллагаа сайжирна.

6.2. Алсын үр дүн /2008 - 2012/

6.2.1. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд тавих хяналт оновчтой, үр дүнтэй болж, архидан согтуурахаас сэргийлэх, зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүй, эдийн засгийн орчин бүрдэнэ.

